



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№179 /389/

2022.10.06

Цаг үе, үйл явдал

“АЛТАН НАМАР 2022” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын туслах аж ахуй, алба хаагчдын тарьж ургуулсан хүнсний ногоо, жимс жимсгэнэ болон боловсруулж бэлтгэсэн сүү цагаан идээг худалдан борлуулах “Алтан намар” уламжлалт үзэсгэлэн худалдаа ЗХЖШ-ын жагсаалын

талбайд болж байна. Үзэсгэлэн худалдааны нээлтэд ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах, ЗХЖШ-ын МТГ-ын даргын орлогч, ТХ-ийн дарга хурандаа Б.Энхболд, штабын дарга хурандаа З.Баянмөнх болон “Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний

заах арга зүйн цугларалт”-д оролцсон ЗХЖШ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, нэгтгэл, анги байгууллагуудын захирагч, дарга нар оролцсон юм. ЗХЖШ-ын МТГ-ын штабын дарга хурандаа З.Баянмөнх үйл ажиллагааг

нээж, нийт бие бүрэлдэхүүнд ургацын баярын мэндийг дэвшүүлсэн бөгөөд “Алтан намар 2022” үзэсгэлэн худалдааны азтанг шалгаруулж 10 хүнд төмс, хүнсний ногооны дээж, 5 хүнд хундан цагаан хонь авах эрхийн бичгийг гардуулав.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
7	-6


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.410.00	3.460.0
EUR	3.410.0	3.460.0
CNY	481.00	485.00
RUB	52.70	53.30
JPY	24	24.40
KRW	2.37	2.42

ЗУРХАЙ



2022.10.06 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 11

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ХАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Эрхтэн хурц болно.

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

06.58-18.23

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

АХМАД ДАЙЧДАДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий ассамблейгаас жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийг “Ахмадын баяр” болон тэмдэглэж байхыг тунхагласны дагуу Манай улс 1992 оноос хойш 30 дахь жилдээ тэмдэглэж байна.

Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 110

дугаар анги эл өдрүүдэд Орхон аймаг дахь Ёс заншлын өргөөнд “Олон Улсын ахмадын баярын өдөр”-ийг тохиолдуулан ахмад буурлуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

Энэ үеэр залуу, халуун насаа эх орноо батлан хамгаалах эрхэм үйлс, их бүтээн байгуулалт, цэрэг дайчдыг

сургаж мэргэшүүлэхэд хөдөлмөр, зүтгэлээ зориулсан зарим ахмадыг Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медаль, Орхон аймгийн Засаг даргын “Хүндэт жуух бичиг”-гээр шагнаж урамшуулан, дурсгалын зүйл гардуулсан аж.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 624,918,248

Эдгэрсэн

Нийт: 604,777,610

Нас барсан

Нийт: 6,555,413

Цаг үе

МӨРДЭСТЭЙ ГЭР БҮЛИЙН БЯЦХАН ОХИН ХАНДИВЫН ТУСЛАМЖ ХҮСЛЭЭ



НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийг Олон улсын Ахмадын баяр болгон тэмдэглэж байхаар тунхагласны дагуу манай улс 1992 оноос хойш 30 дахь жилдээ тэмдэглэж байна.

Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 110 дугаар анги эл өдрүүдэд Орхон аймаг дахь Ёс заншлын өргөөнд тус ангиас тэтгэвэр, чөлөөнд гарсан ахмад буурлуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ.

Энэ үеэр залуу, халуун насаа эх орноо батлан хамгаалах эрхэм үйлс, их бүтээн байгуулалт, цэрэг дайчдыг сургаж мэргэшүүлэхэд хөдөлмөр, зүтгэлээ зориулсан зарим ахмадыг Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүндэт медаль, Орхон аймгийн Засаг даргын "Хүндэт жуух бичиг"-ээр шагнаж урамшуулан, дурсгалын зүйл гардуулсан юм.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай!
Хандивын данс

ХААН БАНК: 5779009614 /Ээж Э.Чинтунгалаг/
Харилцах утас: Аав Ш.Баттүвшин 91887525, ээж Э.Чинтунгалаг 90857525

ЗАРЛАЛ

Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавх, оролцоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "НҮБ-ын штабын ажилтны дамжаа"-г 2022 оны 10 дугаар сарын 17-ноос 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн Энхийг дэмжих ажиллагааны сургалтын төвд зохион байгуулна.

Дамжаанд суралцах хүсэлтэй цэргийн алба хаагчид ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын Энхийг дэмжих ажиллагааны хэлтэст доорх материалыг бүрдүүлэн 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн дотор ирүүлнэ.

Үүнд:

1. Харьяа анги, байгууллага, төрлийн цэргийн командлал болон ЗХЖШ-ын бүтцийн нэгжийн удирдлагын зөвшөөрсөн цохолттой хувийн өргөдөл;
2. Жолооны үнэмлэхийн хуулбар;
3. Товч судалгаа /Анги, албан тушаал, цол, овог нэр, нас, боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа, Анги байгууллагад ажилласан байдал, ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал/

Анги	Албан тушаал	Цол	Овог, нэр	Нас	Боловсрол, цэргийн мэргэжил, дамжаа	Анги, байгууллагад ажилласан байдал	Одоогийн албан тушаалд томилогдсон огноо	ЭДА-нд үүрэг гүйцэтгэсэн байдал

Жич: Шаардлагатай нэмэлт мэдээллийг АУГ-ын ЭДАХ-ийн psod@mil.gov.mn цахим шуудангаар болон /3203, 88136757, 99732447/ дугаарын утсанд холбогдож тодруулна уу.

ЗХЖШ-ЫН АУГ-ЫН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

"ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН ЛАВЛАХ" АППЛИКЕЙШНД "МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРМҮҮД" ОРЛОО



"Цэргийн алба хаагчийн эрх зүйн лавлах" аппликейшнд шинэчлэл хийгдэж МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 180 дугаар ЗАРЛИГААР батлагдсан "МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН НИЙТЛЭГ ДҮРМҮҮД" орлоо.

Тухайн аппликейшнийг Төрийн нууцын зэрэглэлд хамаарахаас бусад төрийн албаны хууль, дүрэм журам болон батлан хамгаалах салбарын хэмжээнд дагаж мөрддөг цэргийн албаны холбогдолтой хууль, тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг цахим хэлбэрээр нэгтгэх, батлан хамгаалах салбарын бие бүрэлдэхүүний цэргийн алба, сахилга зохион байгуулалт, төрийн албан хаагчийн болон офицер, ахлагчийн ёс зүйг дээшлүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан юм. Одоогоор тус

Төрийн байгууллагын стратеги-2030, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Батлан хамгаалах багц хууль, Монгол улсын цэргийн нийтлэг дүрмүүд-2022, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Зэвсэгт хүчний офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм, Цэргийн албан хаагчийн хувцас өмсөх дүрэм, Цол олгох журам, Энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах журам зэрэг эрх зүйн баримтуудыг оруулаад байна.

Гар утасныхаа App store, Google Play Store програмуудын хайх хэсэгт "ЦАХ-ийн эрх зүй" гэж бичихэд ЗХЖШ-ын лого бүхий "ЦАХ-ийн эрх зүй" аппликейшн гарч ирнэ. Мөн дараах QR кодыг гар утсаараа уншуулан татаж авна уу.

Фото агшин



Цэх зогсож, хөл тавих чадал харивч Цэрэг хүн цэргээрээ л үлддэг...

100 настай ахмад дайчин Т.БАТ-ОЧИР гуайн Монгол Улсын ГАВЬЯАТ ХОЛБООЧИН цол хүртэхдээ ёслон илтгэж буй агшин